



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 528

Улаанбаатар хот

“ҮСҮ ХААБ” ХХК, “Бурхант таван эрдэнэ ХААБ” ХХК-иудад
“тосны ургамал /рапс/” гэсэн бараа, түүхий эдийн нэр
төрлөөр зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.3, 1.4 дэх заалт болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/135 дугаар тушаалыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “ҮСҮ ХААБ” ХХК, “Бурхант таван эрдэнэ ХААБ” ХХК-иудад “тосны ургамал /рапс/” гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа нэмж эрхлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэмж авсан “тосны ургамал /рапс/”-ын арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн нэг удаагийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус бүр 50,000 /тавин мянга/ төгрөгөөр тогтоосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000890